

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 11 дүгээр сарын 10

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох заалтуудын 2023 оны 10 дугаар сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээний хэрэгжилтийг хамруулсан болно. Үүнд:

Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтод тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Хэрэгжилт: “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” системийг нэвтрүүлэх арга хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын “Тоног төхөөрөмж” багцаас 470.0 сая төгрөгийг гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлэхээр 2022 онд төлөвлөн тус яамны Төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр гүйцэтгэгч байгууллагатай 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “нууц” гэрээ байгуулсан. Гэрээний хэрэгжилтийг үндэслэн ажлын даалгаврын дагуу программ хангамжийг хүлээн авснаар 2022 онд санхүүжилт болох 470.0 сая төгрөгийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 100 хувь гүйцэтгэгчид олгосон.

Төлөвлөгөөний дагуу энэ онд программыг үе шаттай хөгжүүлж, 10 дугаар сард “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд визийн зөвшөөрөл, виз, оршин суух зөвшөөрлийн хүсэлт шинээр гаргах болон “Wechat pay” төлбөрийн үйлчилгээг 10 дугаар сарын 30-ны өдөр нэвтрүүллээ. Хөгжүүлэлтэд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилт 10 дугаар сард 70 хувьтай үнэлэгдлээ.

Дээрх арга хэмжээний хүрээнд “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийн үйл ажиллагаа жилийн эцэст хэвийн явагддаг болсон байх зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй тул хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР